

03 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Төсөвт 5 байгууллагуудын төрийн албан хаагчдыг Алсын хараа 2050 богино хугацааны цахим сургалтанд хамруулж 93 төрийн албан хаагч сертификат үнэмлэх авсан.

Улаанбаатар хотод 03/15 нд Нутгийн золголтын арга хэмжээг зохион байгуулж сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны тайлан болон сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулж ажилласан. Нийт 80 гаруй нутгийн уугуул иргэд хүрэлцэн ирсэн. Багуудын хурлуудыг зохион байгуулж Сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны тайлан 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл Сумын түүхт 100 жилийн ойг угтан хийх ажлын төлөвлөгөө зардлын тооцоо хандив дэмжлэгийн талаарх мэдээлэл 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга авах, 2023 оны ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ажлууд болон 2022 оны ОНХС-ын гүйцэтгэл зэргийг танилцуулан мэдээлэл хүргэн иргэдийн санал бодлыг сонсож ажилласан. Нийт 5 багийн Иргэдийн нийтийн хуралд 353 иргэд оролцож мэдээ мэдээллийг сонслоо.

Улсын бүртгэлийн үйлчилгээг нийт 54 иргэнд үзүүлсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл газар болон түүнтэй холбоотой 2 бүртгэл хийгдсэн. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл 3 хийгдсэн. Тоон гарын үсэг 6 иргэнд олгосон. Алдарт эхийн одонгийн материалыг бүрдүүлж сумын хэмжээнд 16 эхийн одонгийн материалыг аймгийн ТЗУХ-т хүргүүлж ажилласан.

Архив албан хэрэг хөтлөлт: 1-р улирлын байдлаар Нийт “А” Захирамж 40. Үүнээс Хөрөнгө санхүүтэй холбоотой - 11, ажлын хэсэг байгуулах тухай - 5, газартай холбоотой - 5, үйл ажиллагаатай холбоотой /жишээ нь цэргийн бүртгэл, статистикийн мэдээ тайлангийн график батлах, хурдан морьны уралдаан зохион байгуулахыг хориглох, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах гэм мэт/ -10, үнэлгээний хороо байгуулах тухай 4, бусад – 5 / оршуулгын тэтгэмж, харгалзан дэмжигч томилох бүтэц орон тоо батлах/. Энэ оноос захирамж тушаалын номер авч үлдээд дараа нь нөхөж гаргана гэсэн асуудал байхгүй байна. “Б” Захирамж 1 гарсан. “А” Тушаал – нийт 5 гарсаны 5 нь хөрөнгө санхүүтэй холбоотой, урамшуулал, цалин шинэчлэн тогтоох. “Б” Тушаал нийт 8 гарсан. Б тушаалын хувьд хүний нөөцтэй холбоотой тушаалууд байна. Ирсэн бичиг: Нийт ирсэн бичиг 81 үүнээс хариутай нь 21 хугацаандаа явсан 16, хугацаа болоогүй 6 хугацаа хоцорсон 0. Явуулсан бичиг 78.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, хамтарсан багийнхан болон төрийн албан хаагчдад аймгийн Прокурорын газрын прокурор ирж сургалт

мэдээллийг зохион байгуулж жилийн ажлын төлөвлөгөөнд зөвлөн тусалж цаашид хийх ажлын талаар зааж чиглүүлж ажилласан. Нийт 65 хүн хамрагдсан.

Сумын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг боловсруулж батлуулсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч сумдын ЗДТГ-ын санхүүгийн алба нарт Эрхийн бүртгэлийн системийн хэрэглэгчийн эрхийн тохиргоо хийх төрийн сангийн удирдлагын цахим системийн нэхэмжлэх, зарлага, тайлан модулийг ашиглах талаар заавар зөвлөгөө өгсөн. Төрийн сангаар дамжуулан хийгдэх төлбөр тооцоог холбогдох хууль тогтоомж, заавар журмын хүрээнд холбогдох байгууллагуудаас ПОРТАЛ системээр хянах хүлээн авав. 2022 оны санхүүгийн тайланг төрийн сангийн ахлах нягтлан бодогчтой тулгалт хийх ажлаар 2 удаа аймаг явж тулгалт хийж дууссан. 2022 оны 03 сарын 25 нд төрийн сантай тайланг бүрэн нийлсэн. 2024 оны ОНХС-ийн санал асуулга авах ажлаар 5 –н багийн иргэдийн нийтийн хуралд оролцож ОНХС-ын 2022 оны гүйцэтгэл болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл өгч асууж тодруулсан зүйл дээр нэмэлт тайлбар өгч ажилласан.

Авто тээврийн өрийн судалгааг авч татварын өртэй иргэдтэй холбогдон татвараа төлөхийг анхааруулж шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэж ажиллаж байна. Тайлант оны хяналтаар ногдуулсан ҮХЭХАТ-ыг хуулийн хугацаандаа төлөхийг 40 аан болон хувь хүмүүст анхаарууллаа. Тайлант онд үүссэн газрын төлбөрийн нэхэмжлэхийг барагдуулахыг газрын даамалтай хамтран 3 уурхайд мэдэгдсэн. / Хунт өгөөж, Нутгийн анар, Хос далбаа/ Хураагчийн сургалтад 3/2-3/10 ны хооронд 7 хоног амжилттай хамрагдаж ТУБ-ийн шалгалтад 82 оноогоор тэнцсэн.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сарын 16 нд хуралдуулж ахмадын асаргаа сунгах 2 иргэний хүсэлт, албан газрын харьяалалгүй ахмадын жагсаалтыг хэлэлцэн 352 ахмадын хүндэтгэлийн ehalamj.mn системд бүртгэлээ. ХЭБҮ-нд энэ сард 6 өрхийн 29 иргэний 296,0 мян төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

ХЭДС- аас олгогдох төслүүд зарлагдаж Мөнххаан сумын зар зарлалын нэгдсэн FB группэд мэдээллийг хүргэсэн. Эргэн төлөвлөлтийн хуваарийн дагуу 795,0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Хугацаа хэтэрсэн эргэн төлөлт 650,0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Туслах малчид сумын хэмжээнд 55 байгаагаас туслах ммалчин, ажил олгогч малчинтай гэрээ байгуулах ажлаар 3 малчинтай гэрээ хийсэн. Багийн иргэдийн хурлаар сургалт мэдээлэл өгч гэрээ байгуулах ажлыг эрчимжүүлэ 40 хувьд хүргэж ажиллана.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Эрүүл мэндийн даатгалд 18 иргэн даатгуулсан. Сайн дурын даатгалд шинээр 4 иргэн хамрагдсан. Мөн өндөр насны тэтгэвэр авагч 5 иргэн банкаа солих хүсэлт өгч хүсэлтийг баталгаажуулсан. Группын тэтгэвэр авагч 3 иргэн группээ сунгуулж тэтгэврийг нөхөн олгов. Шинээр өндөр насны тэтгэвэр 2 иргэний материалын хүлээн авсан. 0-3 хүртэлх насны эх шинээр 1 эх даатгуулсан. Төсөв болон ААН- үүдийн өр авлагын талаар мэдээллийг нягтлан нарт нь хэлж өр авлагыг барагдуулах талаарх ярилцлаж зарим өрийг барагдуулсан. Жирэмсэн болон амаржсаны 7 эхэд тэтгэмж олгоод байна. Мөн групп сунгасан 4 тэтгэвэр авагчдад тэтгэврийг нөхөн олгоод байна.

ЕБС- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын харьяат Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Батсүхийн Загдрагчаагийн нэрэмжит Жудо бөхийн өсвөр үеийн ААШ тэмцээн Сүхбаатар суманд амжилттай зохион байгуулагдаж Тус тэмцээнд Биеийн тамирын 1багшийн бэтгэсэн баг багийн дүнгээр ДЭД байр эзэллээ.

Төрөлжсөн хичээлүүдийн олимпиадын 2-ын даваанд 4 багш медальт байранд, ахлах ангийн 5 сурагч медальт байранд шалгарч нийт 9 медалийн болзол хангасан.

ҮСГЭН ӨРӨГ Анхдугаар олимпиад Сүхбаатар аймгийн хэмжээнд 1-5-р ангийн 440 сурагчид оюун ухаанаа уралдуулснаас 5 сурагч шагналт байранд шалгарлаа.

Багшийнтөрөлд: "ШИЛДЭГ БАГШ"-ийн болзол 1 багш хангасан.

Төрийн соёрхолт, урлагийн гавьяат зүтгэлтэн нэрт хүүхдийн зохиолч ЖАМБЫН ДАШДОНДОГ агсны нэрэмжит "УРАН ЖИРГЭЭ-2023" аймгийн уралдааныг аймгийн Гэрбүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газар хамтран зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 13 сумын 67 хүүхэд оролцсноос 116 ангийн сурагч Тэргүүн байранд шалгарч аймгаа төлөөлөн улсын уралдаанд оролцох ЭРХИЙН_БИЧИГ гардан авлаа.

ЭЕШ-ийн цахим бүртгэлийг хугацаанд нь хийж дууссан. 2 хичээлээр 11 сурагч, 3 хичээлээр 18 сурагч, 4 хичээлээр 5 сурагч тус тус бүртгэгдсэн.

ЯХИС болон сум, сургууль хамтарсан 3 талт гэрээг НТБ-ын 3, ЕБС-ийн 2 багт хийж төслийн газарт хүргүүлсэн. ЕZЕL төслийн хосолсон ангийн залуучуудын бүртгэлийг хийж хаврын ангийн нээлтийг хийж хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн.

Хүүхдийн цэцэрлэг: Энэ амралтын өдрүүдээр бүтээлч үйл ажиллагаагаа хөгжүүлэх, хүүхэд хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор багш [П. Оюунтуяа](#) декупаж урлалын ахисан түвшинд, багш [Э. Мөнхтоогоо](#) макраме урлалын сургалт, багш [Миеэсүрэн М.](#) хүүхэддэйн дүр бүтээх, комик манга, 2D анимэйшн, график дизайны сургалт, туслах багш [Номинчулуун Жаргалмөнхийн](#) савхин урлалын сургалтад тус тус хамрагдлаа.

7 хоногийн ажлын төлөвлөгөөний хүрээнд, багш нарын туршлагаа солилцох уулзалт ярилцлагын цагаар, багш [П. Оюунтуяа](#) "Хүүхдийн дууг хэрхэн понаграмм болгох вэ? Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд яаж ашиглах вэ?" сэдвээр мөн туслах багш Т.Болорчимэг эпокси урлалын талаар туслах багш нартаа мэдээлэл өгч, сургалт үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгч, туршлагаа хуваалцав.өөрийн туршиж хэрэгжүүлж буй арга туршлагаа танилцуулж, хуваалцлаа.

Хүүхдийн цэцэрлэгийн "Залуучуудын зөвлөл"-өөс "Монгол цэргийн өдөр"-т зориулсан "Шилжин явах цомын төлөөх" волейболын тэмцээнийг, эрэгтэй баг тамирчдын дунд зохион явуулж, тэмцээнд нийт 8 баг тамирчид оролцлоо. Энэхүү тэмцээнийг эхний жилдээ зохион байгуулсан ба, цаашид жил бүр уламжлал болгон зохион явуулах юм.

Хүүхэд багачуудад монгол өв уламжлал, монгол бөхөө дээдлэн хүндлэх, сурталчлан таниулах, үндэсний бөхөөр хичээллэх хүсэл сонирхлыг бий болгох зорилгоор 4-5 настай хүүхдүүдийн дунд "Хуйрнан шуугигч" үндэсний бөхийн барилдааныг зохион явууллаа.

.Хүүхдийн хөгжлийн төлөө хамтран ажилладаг цэцэрлэг, багш ажилчид, эцэг эх, асран хамгаалагчдын хамтарсан уулзалт, ярилцлага боллоо. Энэхүү үйл ажиллагааг "Талархлын өдөрлөг" нэртэйгээр "Хүүхдээ ойлгоё, дэмжье, хамгаалъя" уриатайгаар зохион явуулж, байгууллагын үйл ажиллагаагаа танилцуулах, амжилт үр дүнгийн талаар мэдээлэл хүргэх, харилцан ярилцах, санал бодлоо солилцох, хүүхдийг хөгжүүлж буй хөтөлбөр төлөвлөгөө, багшийн арга туршлага, бүтээлч үйл ажиллагаануудыг танилцуулах, эцэг эх асран

хамгаалагчдын санал бодлыг сонсох, үргэлж дэмжиж хамтарч ажилладаг тэдэнд талархал илэрхийлэх зэрэг олон ажлуудыг, 10 бүлэг бүр өөр өөрийн өнгө төрхтэйгээр зохион байгууллаа.

Соёл, урлагын үйлчилгээ: Байгууллагын ажилтан албан хаагчдад шинээр хэрэгжиж буй хууль тогтоомжийн чиглэлээр сургалтыг 1 удаа, Сүхбаатар аймгийн хэмжээнд Хүүхэд хөгжил хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан гарсан Аймгийн ИТХ-ын тогтоол Аймгийн засаг даргын захирамж болон түүнтэй холбогдуулан гарсан төлөвлөгөө, соёл урлагийн хэлтсийн даргын ажлын чиглэлийг ажилтнуудад танилцуулан арга зүйн зөвлөгөө чиглэл өгч байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталлаа.

1.1 Байгууллагын 1-р улирлын статистик мэдээ мэдээллийг соёл урлагийг газарт хүргүүлэн ажиллаа

1.2 МУ-ын Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Цахим соёл” арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй шилэн кабелийн өндөр хурдны интернэтэд холбогдож төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх нөхцөл боломжоор хангагдаад байна.

2.1 Соёл урлагийн нэгдсэн 12 арга хэмжээ гадны тоглолт 5, кино үзвэрийн үйлчилгээ 1, байгууллагаас зохион байгуулсан барга хэмжээнд нийт 1890 үйлчлүүлэгч хамрагдсан байна.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1 Номын сангийн 1-р улирлын статистик тоон мэдээллийг аймгийн нийтийн номын санд хүргүүллээ.

Номын сангийн фондны тооллогыг соёлын төвийн даргын 2023 оны 01 сарын 05-ны өдрийн А\01 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг тооллогын ажлыг зохион байгуулж нийт 3890 ширхэг номыг тооллогонд хамруулан 120 ширхэг номыг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгээд байна.

3.2 Номын сангийн уншлагын танхимын тохижилт үйлчилгээний ажлыг сайжруулан ажиллаж байна.

3.3 Номын сангийн явуулын үйлчилгээг 6 удаа танхимын үйлчилгээг 18 удаа хүргэн танхим болон явуулын үйлчилгээгээр 102 иргэнд 144 номоор үйлчиллээ.

3.4 Номын сангийн олон нийтийн ажлын хүрээнд “Ээждээ захидал бичээрэй захидлын уралдаан”-ыг хүүхэд, насанд хүрэгчдийн 2 ангиллаар зохион байгуулан нийт 21 захидал ирснээс эхний байранд 6 захидлыг шалгаруулан 250,000 төгрөгийг шагналын зардалд зарцуулан ажиллаа

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 Монгол Улсын соёлын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А\34 тоот тушаалаар Хүүхэд залуучуудад үндэсний түүх, соёл, өв уламжлал, ёс заншлаараа бахархах, хүндэтгэн дээдлэх зорилгоор “Музейн нээлттэй өдөр”-ийг аймгийн Соёл урлагийн газраас өгсөн удирдамжийн дагуу зохион байгуулан ажилласан.

1. Тус арга хэмжээний хүрээнд 460 сурагчид 410 иргэдийг үйл ажиллагаандаа хамруулан тусгай өгөгдсөн брэндбүүкийг ашиглан олон нийтэд Музейн нээлттэй өдөр”-ийг сурталчлах ажлыг цахимаар зохион байгуулж 340 гаруй иргэдэд цахим үйлчилгээг хүргэн ажиллаа. Тус арга хэмжээг зохион байгуулахад нийт 640,000 төгрөгийг шагнал урамшуулалд олгон ажиллаа.

2. Үндэсний түүх, соёл, өв уламжлал, ёс заншлын сэдэвтэй тусгай үзэсгэлэн

- Нутгаас төрөн гарсан алдартнуудын уран зургийн үзэсгэлэнг зохион байгуулж үзэсгэлэнгийн арга хэмжээнд нийт 189 иргэд үйлчлүүлэгчдийг хамрууллаа
- 3. Музейн боловсролын хөтөлбөр
 - Үндэсний түүх соёлоо сурталчлан таниулах зорилгоор “Дээлтэй монгол өдөрлөг” , “Дөрвөн бэрх” тэмцээнийг Хүүхэд, насанд хүрэгчдийн ангиллаар зохион байгуулан тус арга хэмжээнд нийт 124 иргэд хүүхдийг оролцуулж 560 гаруй иргэдэд монгол ахуй, үндэсний түүх соёлыг сурталчлан таниулж ажиллаа.
- 4. Эх орончдын өдөрт зориулсан лекц уулзалт
 - Эх орончдын өдөрт зориулсан лекц уулзалтыг ЕБС-ийн сурагчидтай хамтран зохион байгуулж үйл ажиллагаандаа ахлах ангийн 31 сурагчдыг хамруулан сурталчлан таниулж ажиллаа.
- 5. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай арга хэмжээ
 - Ахмад настан, хүүхэд залуучуудад зориулсан Музейн боловсрол олгох хөтөлбөрт арга хэмжээг сумын Хүүхдийн элчтэй хамтран зохион байгуулж үйл ажиллагаандаа дотуур байрны 79 сурагчдыг 100 хувь хамруулан сумын 5 багаас 56 ахмад настнууд 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулж ажиллаа.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1 Хөгжим, бүжгийн багшийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1-р улирлын дугуйлан сургалтын үйл ажиллагааны үр дүнг тайлагнах өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.

5.2 Тус арга хэмжээнд 4 төрлийн дугуйланд суралцдаг 67 сурагчид 17 эцэг эх хамрагдан тайлант өдөрлөгийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд урлаг уран бүтээлийн зардлаас 450,000 төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Урлаг уран бүтээлийн чиглэлээр

6.1 Сумын 100 жилийн ойд зориулсан нутгийн онцлогийг харуулсан 2 шинэ уран бүтээлийг туурвихаар бэлтгэл ажилдаа ороод байна.

6.2 М.Дугаржавын 130 жилийн ойд зориулсан “Уртын дуучдын улсын уралдаан”-ыг 5-р сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар Сумын ЗДТГ, УБ дахь нутгийн зөвлөл аймгийн СУГ, Жаахан театртэй хамтран зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2023 оны 03 сарын 29-ны байдлаар 38өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 17 насанд хүрэгчид, 21хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг ЭМГазар болон бусад холбогдох газартай хамтран төлөвлөгөөг гаргаж батлуулан ажиллаж байна. “Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдөр”-ийг угтан төлөвлөгөө гарган дараах ажлуудыг зохион байгууллаа.

9-12 ангийн сурагчдын дунд тандалт судалгаа хийж 165 хүүхдэд сүрьеэ өвчний талаар мэдээлэл өгч, цээжний рентген авч, үзлэг, асуумж авч дүгнэн

ажиллалаа. Мөн ажилчдад “Цэрний шинжилгээ өгөх үйлчлүүлэгчийг хэрхэн таних, яаж авах талаар” мэдээлэл сургалт зохион байгууллаа.

“Энэ жилдээ-эрүүл жиндээ” аяны хүрээнд төсөвт байгууллагын албан хаагчдаас БЖИ болон бүсэлхийн тойрог, насны дундаж үзүүлэлтийг гарган дүгнэж ЭМГазрын мэргэжилтэнд илгээсэн.

Амбулаторийн үзлэг 637, урьдчилан сэргийлэх үзлэг 205 байна.

Түргэн тусламжийн дуудлага 78ирснээс алсын дуудлага–11, ойрын дуудлага67ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Аймгийн Засаг даргын А/37 тоот захирамжаар 2 ажлын хэсэг гарч сумын төв болон 3-р багийн нутаг Цээл нуурын орчмын газарт хорогдсон малын 526 сэг зэмийг цуглуулан булж устгах ажлыг зохион байгуулсан. Нийт 36,2 мянган мкв талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийгээд байна.

2022 оны жилийн эцсийн мал тооллогын нэгдсэн тулгалтын ажлыг МААНС-д хийж дуусгаад байна.

Гурав: Газрын харилцаа, байгаль орчны чиглэлээр:

ТЖГЗБТөлөвлөгөөний дагуу 4 нэгж талбарт дуудлага худалдааг танхимаар амжилттай зохион байгуулж нийт 3 нэгж талбар 40 сая төгрөгийн үнэ хүрч, ялагч иргэдтэй гэрээ байгуулаад байна. 1 нэгж талбар оролцогчгүйн улмаас цуцлагдсан. Мөн газар чөлөөлөх иргэдтэй уулзан гэрээ байгуулж, газар чөлөөлөлтийн ажил эхэлж байна. 1-5 багуудын хурал хийгдэж түүнд газрын харилцааны мэдээ мэдээлэл зөвлөмж хүргэн ажиллаж байна. 2023 оны 03 сарын 03-ны өдрийн ЗДТГ-ын даргаар “Сэг зэмийн устгал ариутгалын удирдамж” гарган батлуулан 2 хонгийн хугацаанд ажлыг хийж гүйцэтгэсэн. Сумын төвийг тойрсон эзэнгүй хог хаягдал, малын сэг зэмийн цэвэрлэгээг хийж ариутгал халдваргүйжилт хийж ажилласан. Үүнд шатах тослох материал 130000 төгрөгийн зардал гарсан. Бог мал 198, Бод 37 нийт 235 малын сэг зэмийн цэвэрлэгээг хийсэн. Нийтийн эзэмшлийн 29.3м2 талбайд ариутгалыг хийсэн. Тус сумын мод үржүүлгийн 10:8хүлэмж болон гадна талбайн тарьцанд цасны хучлагыг 2 удаа хийж ажилласан.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.

